

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛЬД ОРОЛЦОЖ БАЙГАА НАМ,
ЭВСЭЛ, НЭР ДЭВШИГЧ СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАН ГАРГАХ,
СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАНД АУДИТ ХИЙХ, ХЯНАХ, ДҮНГ
НИЙТЭД МЭДЭЭЛЭХ, ТАНИЛЦУУЛАХ ЖУРАМ**

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Нэг. Журмын зорилго

1.1.Энэ журмын зорилго нь Монгол Улсын Их Хурлын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн санхүүжилтээ хуулиар хүлээн зөвшөөрсөн, бодит эх үүсвэрээс бүрдүүлэх, зориулалтын дагуу зарцуулах, сонгуулийн санхүүжилтийг сонгогч иргэн, олон нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй, ил тод байлгах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Хоёр. Журмын үйлчлэх хүрээ

2.1.Энэ журмыг Монгол Улсын Их Хурлын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардалд зарцуулах хөрөнгийг хуримтлуулах, сонгуулийн зардал гаргах, сонгуулийн зардлын явцын болон эцсийн тайлан гаргах, сонгуулийн зардлын тайландаа аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулах, Үндэсний аудитын газраас сонгуулийн зардлын тайланг хянаж, дүнг нийтэд мэдээлэх, танилцуулахад дагаж мөрдөнө.

Гурав. Нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1."сонгууль" гэж Монгол Улсын Их Хурлын ээлжит, ээлжит бус болон нөхөн сонгуулийг;

3.1.2."нэр дэвшигч" гэж энэ журамд тухайлан зааснаас бусад тохиолдолд Улсын Их Хурлын сонгуульд нам, эвслээс нэр дэвшигч болон бие даан нэр дэвшигчийг;

3.1.3."аудитын хуулийн этгээд" гэж Аудитын тухай хуулийн 3.1.4-т заасан этгээдийг.

ХОЁДУГААР БҮЛЭГ. СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ХӨРӨНГӨ

Дөрөв. Сонгуулийн зардлын данс

4.1.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 51.1-д зааснаар сонгуульд оролцож байгаа нам, эвсэл болон нэр дэвшигч тус бүр улсын хэмжээнд сонгуулийн зардлын төгрөгийн нэг данстай байна.

4.2.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 51.2-т зааснаар нам аймаг, нийслэл, сум, дүүрэгт салбартай бол тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэгт сонгуулийн зардлын данстай байж болно.

4.3.Нам, эвсэл, нэр дэвшигчийг сонгуульд оролцуулахаар бүртгэх тухай Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэр гарснаас хойш нам, эвсэл, нэр дэвшигч холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн сонгуулийн зардлын дансыг нээлгэж сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг санал авах өдрөөс 20-оос доошгүй хоногийн өмнө Үндэсний аудитын газарт бичгээр мэдэгдэж, бүртгүүлнэ.

Тав. Сонгуулийн зардлын хөрөнгө

5.1.Нам, эвслийн сонгуулийн зардлын хөрөнгө нь намын өөрийн хөрөнгө, мөнгөн хандиваас бүрдэнэ.

5.2.Нам, эвслээс нэр дэвшигчийн сонгуулийн зардлын хөрөнгө нь намын өөрийн хөрөнгө, нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө, мөнгөн ба мөнгөн бус хандиваас бүрдэнэ.

5.3.Бие даан нэр дэвшигчийн сонгуулийн зардлын хөрөнгө нь нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө, мөнгөн ба мөнгөн бус хандиваас бүрдэнэ.

Зургаа. Сонгуулийн зардалд зарцуулах намын өөрийн хөрөнгө

6.1.Нам Улс төрийн намын тухай хуульд заасны дагуу өөрийн дансанд хуримтлуулсан мөнгөн хөрөнгийг данснаасаа нам, эвслийн сонгуулийн зардлын дансанд оруулан зарцуулах ба намын хувьд энэ журмын 4.2-т заасан сонгуулийн зардлын данс нээлгэсэн тохиолдолд уг дансанд оруулан зарцуулж болно.

6.2.Нам, эвсэл өөрийн нэр дэвшигчийн сонгуулийн зардалд зориулж олгох намын өөрийн хөрөнгийг нам, эвслийн сонгуулийн зардлын данснаасаа тухайн нэр дэвшигчийн сонгуулийн зардлын дансанд шилжүүлэг хийж олгоно.

6.3.Нам, эвсэл зээлийн мөнгөн хөрөнгийг сонгуулийн сурталчилгаанд зарцуулахыг хориглоно.

Долоо. Сонгуулийн зардалд зарцуулах нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө

7.1.Сонгуулийн зардалд зарцуулах нэр дэвшигчийн өөрийн хөрөнгөд Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасан орлогод хамаарах мөнгөн хөрөнгө хамаарна.

7.2.Нэр дэвшигч энэ журмын 7.1-д заасан мөнгөн хөрөнгийг өөрийн данснаасаа сонгуулийн зардлын дансандаа оруулан зарцуулна.

7.3.Нэр дэвшигч зээлийн мөнгөн хөрөнгийг сонгуулийн сурталчилгаанд зарцуулахыг хориглоно.

Найм. Сонгуулийн хандив

8.1.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 53.1-д зааснаар сонгуулийн хандив нь мөнгөн ба мөнгөн бус хэлбэртэй байна.

8.2.Хандив нь хандивлагчийн өөрийн хөрөнгө, үйл ажиллагааны орлогын чадамжаас хэтрээгүй, бодитой байна.

8.3.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 56.1-д заасан этгээд хандив өгөхийг хориглох ба нам, эвсэл, нэр дэвшигч шаардсан тохиолдолд хандивлагч уг шаардлагыг хангаж байгаа эсэхийг нотлох баримтыг гаргаж өгөх үүрэгтэй.

Ес. Мөнгөн хандив

9.1.Хандивлагч этгээдээс эргэн төлөх нөхцөлгүйгээр нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын дансанд шилжүүлсэн хөрөнгийг мөнгөн хандив гэнэ.

9.2.Мөнгөн хандив нь иргэний хувьд таван сая төгрөг хүртэл, хуулийн этгээдийн хувьд хорин сая төгрөг хүртэл байна.

9.3.Нам, эвсэл, нэр дэвшигч нь мөнгөн хандивыг зөвхөн сонгуулийн зардлын дансанд хүлээж авна.

9.4.Нам, эвсэл болон нэр дэвшигч сонгуулийн зардлын данс хооронд шилжүүлсэн мөнгөн хөрөнгийг хандивт тооцохгүй.

Арав. Мөнгөн бус хандив

10.1.Хандивлагч этгээдээс сонгуулийн сурталчилгаа эхэлсэн өдрөөс дуусах хүртэл хугацаанд зөвхөн нэр дэвшигчид үнэ төлбөргүйгээр үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгийг ашиглуулах, эзэмшүүлэх, үйлчилгээ үзүүлэхийг мөнгөн бус хандив гэнэ.

10.2.Үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгийг ашиглуулах, эзэмшүүлэх мөнгөн бус хандивын гэрээг тухайн эд хөрөнгийн өмчлөгч, эсхүл түүнийг төлөөлөх эрх бүхий этгээдтэй байгуулна.

10.3.Үйлчилгээ үзүүлэх мөнгөн бус хандивыг тухайн үйлчилгээ үзүүлж байгаа этгээд, эсхүл төлөөлөх эрх бүхий этгээдтэй байгуулна.

10.4.Нам өөрийн өмчлөлийн хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгийг нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгаанд ашиглуулж болох бөгөөд энэ нь хандивт тооцогдохгүй.

Арван нэг. Мөнгөн бус хандивын үнэлгээг тодорхойлох

11.1.Мөнгөн бус хандивын зах зээлийн дундаж үнэлгээг дараах журмаар тодорхойлно:

11.1.1.тухайн хөрөнгө, үйлчилгээгээр хангасан хандивлагч энэ төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг бол уг үйл ажиллагааны дундаж үнэлгээгээр;

11.1.2.тухайн хөрөнгө, үйлчилгээгээр хангасан хандивлагч энэ төрлийн аж ахуйн үйл ажиллагааг эрхэлдэггүй бол тухайн газар нутаг дахь энэ төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг этгээдийн үнэлгээний дундаж үнэлгээгээр.

Арван хоёр. Хуулиар зөвшөөрөгдөөгүй хандив

12.1.Дараах хандивыг хуулиар зөвшөөрөгдөөгүй хандивт тооцно:

12.1.1.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 54.4-т заасан шаардлагыг хангаагүй буюу банкны гүйлгээний баримтад хандивлагчийн нэр, регистрийн дугаар болон хандивын эх үүсвэрийн талаарх мэдээлэл бүрэн тусгагдаагүй мөнгөн хандив;

12.1.2.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 54.5-д заасан буцах хаяг тодорхойгүй мөнгөн хандив;

12.1.3.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 56.1-д заасан хандив өгөхийг хориглосон этгээдээс өгсөн мөнгөн ба мөнгөн бус хандив;

12.1.4.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 54.1-д заасан хэмжээнээс хэтэрсэн мөнгөн ба мөнгөн бус хандив.

12.2.Нам, эвсэл, нэр дэвшигчид энэ журмын 12.1-д заасан хуулиар зөвшөөрөгдөөгүй хандивыг хүлээн авч, зарцуулах, ашиглахыг хориглоно.

Тайлбар: *“Буцах хаяг тодорхойгүй мөнгөн хандив” гэж хандивлагчийн нэр, регистрийн дугаар, банкны дансны дугаар зөрүүтэй хандивыг ойлгоно.*

Арван гурав. Хуулиар зөвшөөрөгдөөгүй хандивыг буцаах, улсын орлогод шилжүүлэх

13.1.Нам, эвсэл, нэр дэвшигч хуулиар зөвшөөрөгдөөгүй хандивыг дараах журмаар буцаан шилжүүлэх буюу улсын орлого болгоно:

13.1.1.энэ журмын 12.1.1, 12.1.3-т заасан мөнгөн хандивыг сонгуулийн зардлын эцсийн тайлан гаргахаас өмнө хандивлагч этгээдэд буцаан шилжүүлэх;

13.1.2.энэ журмын 13.1.1-д заасан хугацаанд буцаан шилжүүлээгүй болон энэ журмын 12.1.2-т заасан мөнгөн хандивыг улсын орлого болгох;

13.1.3.энэ журмын 12.1.4-т заасан хандив мөнгөн хэлбэртэй байсан тохиолдолд хуульд заасан хэмжээнээс илүү гарсан хэсгийг улсын орлого болгох;

13.1.4.энэ журмын 12.1.4-т заасан хандив мөнгөн бус хэлбэртэй байсан тохиолдолд тухайн хандивын үнэлгээтэй тэнцэх хэмжээний төлбөрийг улсын орлого болгох.

13.2.Нам, эвсэл, нэр дэвшигч энэ журмын 13.1, 14.1-д заасны дагуу улсын орлого болгох хандивыг улсын төсвийн орлогын нэгдсэн дансанд тушаана.

Арван дөрөв. Хуулиар зөвшөөрөгдөөгүй мөнгөн хандивыг ашигласанд тооцох

14.1.Нам, эвсэл, нэр дэвшигч хуулиар зөвшөөрөгдөөгүй мөнгөн хандивыг хүлээн авснаас хойшхи хугацаанд сонгуулийн зардлын дансны үлдэгдэл тухайн хандивын хэмжээнээс бага болсон тохиолдолд хандивыг ашигласанд тооцож холбогдох нам, эвсэл, нэр дэвшигч хандивыг улсын орлого болгоно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. СОНГУУЛИЙН ЗАРДАЛ

Арван тав. Сонгуулийн зардлын ангилал

15.1.Сонгуулийн зардал нь нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн мөрийн хөтөлбөрөө сонгогчдод сурталчлах, тайлбарлан таниулах зорилготой гаргасан шууд болон шууд бус зардал хамаарна.

15.2.Сонгуулийн шууд зардалд нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн мөрийн хөтөлбөрөө сонгогчдод сурталчлах, тайлбарлан таниулах үйл ажиллагаатай шууд холбогдох дараах зардал хамаарна:

15.2.1.нам, эвслээс нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгаанд зориулж олгосон зардал;

15.2.2.сонин, сэтгүүл, ухуулах хуудас, зурагт самбарт байршуулах хуудас, намын далбаа, уриа, таних тэмдэг бүхий хуудас, хувцас хэвлүүлэх зардал;

15.2.3.телевиз, радио, өдөр тутмын болон бусад сонин сэтгүүл, цахим орчин ашигласны зардал;

15.2.4.сонгогчидтой хийсэн уулзалт, хурал, цуглааны зардал;

15.2.5.ухуулах байр, сонгуулийн сурталчилгаанд ашиглагдах тээврийн хэрэгсэл, бусад тоног төхөөрөмж/чанга яригч, дэлгэц/-ийн түрээсийн болон тэдгээрийг худалдан авсан зардал;

15.2.6.шатахууны зардал;

15.2.7.сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан, менежер, шадар туслах, ухуулагч, ажиглагчийн цалин, урамшуулал.

15.3.Сонгуулийн шууд бус зардалд нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн мөрийн хөтөлбөрөө сонгогчдод сурталчлах, тайлбарлан таниулах үйл ажиллагаанд шууд хамаарахгүй боловч уг үйл ажиллагааг явуулахад зайлшгүй шаардагдах дараах зардал хамаарна:

15.3.1.бараа, ажил, үйлчилгээ худалдаж авсан зардал;

15.3.2.сонгууль эрхэлсэн байгууллага, түүний бүрэлдэхүүний ажлын хэрэгцээнд ашиглахаар эд хөрөнгө түрээсэлсний зардал;

15.3.3.захиргааны зардал;

15.3.4.бусад зардал.

Арван зургаа. Сонгуулийн зардал гаргах

16.1.Нам, эвсэл болон нэр дэвшигчийг сонгуульд оролцуулахаар бүртгэсэн өдрөөс эхэлж, сонгуулийн зардлын тайлан гаргах өдрийг дуусталх хугацаанд энэ журмын 15.1-д заасан зардалд зориулан сонгуулийн зардлын данснаас дансанд шилжүүлэх хэлбэрээр зарлага гаргана.

16.2.Нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын дансандаа хүлээн авсан орлого, гаргасан зарлагыг тухай бүр баримтжуулж ажиллана.

16.3.Нам, эвсэл, нэр дэвшигч нь сонгуулийн зардлын данснаас бэлнээр зарлага гаргахыг хориглоно.

16.4.Дараах дүнгийн нийлбэр нь сонгуулийн зардлын хэмжээнээс хэтрээгүй байна:

16.4.1.сонгуулийн зардлын данснаас гаргасан энэ журмын 15.1, 15.2-т заасан зардлын дүн;

16.4.2.бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан этгээдэд төлөгдөөгүй төлбөрийн дүн;

16.4.3.мөнгөн бус хандивын хэмжээ /энэ заалт нь зөвхөн нэр дэвшигчид хамаарна/.

16.5.Энэ журмын 16.4-т заасан дүн нь сонгуулийн зардлын дээд хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд илүү гарсан хэсэгтэй тэнцэх хэмжээний мөнгөн төлбөрийг нам, эвсэл, нэр дэвшигч улсын орлого болгоно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Арван долоо. Сонгуулийн зардлын санхүүгийн тайлан

17.1.Сонгуулийн зардлын тайлан нь мөнгөн ба мөнгөн бус хөрөнгийн санхүүгийн тайлан байна.

17.2.Сонгуулийн зардлын тайланд нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардалд зарцуулсан хөрөнгийн орлого, түүний эх үүсвэр ба зарлагын мэдээллийг бүрэн тусгана.

Арван найм. Сонгуулийн зардлын санхүүгийн тайлан гаргах

18.1.Нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын санхүүгийн тайланг дараах маягтын дагуу тайлагнаж гаргана:

18.1.1.сонгуулийн зардлын тайлангийн хураангуй тайлан /Маягт-1/

18.1.2.сонгуулийн зардлын дансанд төвлөрүүлсэн нам, нэр дэвшигчийн өөрийн хөрөнгийн тайлан /Маягт-2/

18.1.3.мөнгөн хандивын тайлан /Маягт-3/

18.1.4.мөнгөн бус хандивын тайлан /Маягт-4/

18.1.5.хуулиар зөвшөөрөгдөөгүй хандивын тайлан /Маягт-5/

18.1.6.хуулиар зөвшөөрөгдөөгүй хандивыг буцаан буюу улсын орлогод шилжүүлсэн тайлан /Маягт-6/

18.1.7.сонин, сэтгүүл, ухуулах хуудас, зурагт самбарт байршуулах хуудас, намын далбаа, уриа, таних тэмдэг бүхий хуудас, хувцас хэвлүүлэсний зардлын тайлан /Маягт-7/;

18.1.8.телевиз, радио, өдөр тутмын болон бусад сонин сэтгүүл, цахим орчин ашигласны зардлын тайлан /Маягт-8/;

18.1.9.сонгогчидтой хийсэн уулзалт, хурал, цуглааны зардлын тайлан /Маягт-9/;

18.1.10.ухуулах байр, сонгуулийн сурталчилгаанд ашиглагдах тээврийн хэрэгсэл, бусад тоног төхөөрөмж/чанга яригч, дэлгэц/-ийн түрээсийн зардал, эсхүл тэдгээрийг худалдаж авсан зардлын тайлан; /Маягт-10/

18.1.11.шатахууны зардлын тайлан /Маягт-11/

18.1.12.цалин, урамшуулал /Маягт-12/

18.1.13.сонгуулийн шууд бус зардлын тайлан /Маягт-13/

18.1.14.төлөгдөөгүй байгаа өр төлбөрийн тайлан /Маягт-14/

18.2.Нам, эвсэл, нэр дэвшигч нь сонгуулийн зардлын тайландаа дараах баримтуудыг хавсаргана:

18.2.1.сонгуулийн зардлын тайлантай холбоотойгоор нам, эвсэл, нэр дэвшигчийн тайлбар, тодруулга;

18.2.2.нам болон эвсэлд нэгдсэн намууд, нэр дэвшигчийн өөрийн болон сонгуулийн зардлын дансны хуулга;

18.2.3.сонгуулийн зардлын тайланд тусгасан орлого, зарлага бүрийг нотлох бэлэн бус төлбөр тооцооны нэхэмжлэл, төлбөрийн даалгавар, банкны гүйлгээ хийгдсэн дансны хуулга, бэлэн бусаар төлбөр шилжүүлсэн, хүлээн авсан баримт, төлбөрийн карт болон төлбөр тооцооны бусад баримт;

18.2.4.байгуулсан гэрээ, хэлцлийн хуулбар;

18.2.5.нэр дэвшигч мөнгөн бус хандив авсан бол хандивын гэрээний хуулбар, хандивын гэрээний үнэлгээг зах зээлийн дундаж ханшийг үндэслэн тодорхойлсон болохыг нотлох баримт;

18.2.6.Үндэсний аудитын газар, аудитын хуулийн этгээдээс хууль болон энэ журамд заасны дагуу шаардсан бусад баримт бичиг.

Арван ес. Нам, эвсэл, нэр дэвшигчийн өөрийн хөрөнгийн тайлан

19.1.Нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардалд зарцуулсан өөрийн хөрөнгийн тайланг хөрөнгийн эх үүсвэр болон сонгуулийн зардлын дансанд шилжүүлсэн гүйлгээ тус бүрээр мэдүүлнэ.

19.2.Нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардалд зарцуулахаар өөрийн данснаас сонгуулийн зардлын дансандаа шилжүүлсэн өөрийн хөрөнгийн эх үүсвэрийг тодорхойлох банкны дансны хуулга, бусад нотлох баримтыг гаргаж өгнө.

Хорь. Хуулиар зөвшөөрөгдөөгүй хандивын тайлан

20.1.Нам, эвсэл, нэр дэвшигч хуулиар зөвшөөрөгдөөгүй хандивыг мөнгөн ба бус хандивын тайланд оруулахгүйгээр тусад нь тайлагнана.

Хорин нэг. Сонгуулийн зардлын явцын тайлан гаргах, тайланг хүрүүлэх, нийтэд мэдээлэх

21.1.Нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын явцын тайланг энэ журмын 18-д заасны дагуу гаргаж санал авах өдрөөс 3 хоногийн өмнө дараах журмаар нийтэд мэдээлж, тайланг Үндэсний аудитын газарт ирүүлнэ:

21.1.1.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 47.1.1, 47.1.2-т заасан цахим хуудаст байршуулах;

21.1.2.өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд байршуулах;

21.1.3.мэдээллийн сайт болон бусад олон нийтийн сүлжээнд байршуулах.

21.2.Нийслэлээс бусад тойрогт нэр дэвшигч энэ журмын 21.1-д заасан хугацаанд сонгуулийн зардлын явцын тайлангийн эх хувийг ирүүлэх боломжгүй

тохиолдолд сонгуулийн зардлын явцын тайлангийн цахим хуулбарыг Үндэсний аудитын газрын цахим шууданд илгээж, эх хувийг санал авах өдрөөс 1 хоногийн өмнө Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

21.3.Үндэсний аудитын газар нам, эвсэл болон нэр дэвшигчээс ирүүлсэн сонгуулийн зардлын явцын тайланг хүлээн авмагц нэн даруй өөрийн цахим хуудаст байршуулж, энэ хэсэгт заасны дагуу сонгуулийн зардлын явцын тайлангаа ирүүлээгүй нам, эсвэл, нэр дэвшигчийг нийтэд мэдээлнэ.

Хорин хоёр. Сонгуулийн зардлын эцсийн тайлан гаргах

22.1.Нам, эвсэл санал авах өдрөөс хойш 45 хоногт, нэр дэвшигч санал авах өдрөөс хойш 30 хоногт багтаан сонгуулийн зардлын эцсийн тайланг энэ журмын 18-д заасны дагуу гаргаж аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан Үндэсний аудитын газарт ирүүлнэ.

22.2.Нам, эвсэл, нэр дэвшигч аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулсан сонгуулийн зардлын эцсийн тайланг энэ журмын 21.1-д заасан журмаар нийтэд мэдээлнэ.

22.3.Үндэсний аудитын газар энэ журмын 22.1-д заасан хугацаанд сонгуулийн зардлын эцсийн тайлангаа ирүүлээгүй нам, эвсэл, нэр дэвшигчийн нэрийг нийтэд мэдээлж, аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулсан сонгуулийн зардлын тайланг нийтэд нь өөрийн цахим хуудастаа байршуулна.

22.4.Үндэсний аудитын газар энэ журмын 22.1-д заасны дагуу ирүүлсэн сонгуулийн зардлын эцсийн тайланг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянаж, дүнг өөрийн цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан нийтэд мэдээлнэ.

22.5.Үндэсний аудитын газар сонгуулийн зардлын эцсийн тайланг хянахдаа Төрийн аудитын тухай хууль болон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн хуулийн 58.2.2-58.2.4-т заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

22.6.Нам, эвсэл, нэр дэвшигч, холбогдох бусад этгээд нь Үндэсний аудитын газраас шаардсан мэдээлэл, баримт бичгийг тогтоосон хугацаанд гаргаж өгөх үүрэгтэй.

22.7.Нам, эвсэл, нэр дэвшигч энэ журмын 13, 14, 16.5-д заасан мөнгөн хөрөнгийг улсын орлого болгоогүй тохиолдолд Үндэсний аудитын газар холбогдох нам, эвсэл, нэр дэвшигчид хугацаатай албан шаардлага өгч, биелэлтийг хангана.

Хорин гурав. Аудитын хуулийн этгээд сонгуулийн зардлын тайланд дүгнэлт гаргах

23.1.Сонгуулийн зардлын эцсийн тайланд аудит хийх аудитын хуулийн этгээд нь Аудитын тухай хуульд заасны дагуу ажил төрөл, хувийн харилцаа холбоо, ашиг сонирхлын хувьд нам, эвсэл, нэр дэвшигчээс хараат бус байх шаардлагыг хангасан байна.

23.2.Сонгуулийн зардлын эцсийн тайланд аудит хийхээр нам, эвсэл, нэр дэвшигчтэй гэрээ байгуулсан аудитын хуулийн этгээд нь гэрээ байгуулснаас хойш хоёр хоногийн дотор энэ тухайгаа Үндэсний аудитын газарт мэдэгдэнэ.

23.3.Аудитын хуулийн этгээд энэ журмын 23.2-т заасны дагуу гэрээ байгуулснаас хойш аливаа шалтгаанаар сонгуулийн зардлын эцсийн тайланд аудит хийгээгүй, аудит хийхээс татгалзсан тохиолдолд энэ тухай мэдэгдлийг тайлбарын хамт Үндэсний аудитын газарт ирүүлнэ.

23.4.Аудитын хуулийн этгээд сонгуулийн зардлын эцсийн тайланд хийх аудитыг тухайн нам, эвсэл, нэр дэвшигчээс энэ журмын 18.1-д заасан маягтын дагуу

гаргасан тайлан, 18.2-т заасан баримт бичиг, бусад шаардлагатай санхүүгийн баримтад үндэслэн хийнэ.

23.5.Аудитын хуулийн этгээд дараах асуудлуудын хүрээнд сонгуулийн зардлын эцсийн тайлан аудит хийж дүгнэлт гаргана:

23.5.1.сонгуулийн зардлын тайланг батлагдсан маягтын дагуу иж бүрэн гаргаж, баталгаажуулсан эсэх;

23.5.2.сонгуулийн зардалд зарцуулсан намын болон нэр дэвшигчийн өөрийн хөрөнгийн эх үүсвэр нь тодорхой, бодитой эсэх;

23.5.3.хүлээн авсан мөнгөн хандив нь хуулиар зөвшөөрөгдсөн, эх үүсвэр нь тодорхой, бодитой эсэх;

23.5.4.хүлээн авсан мөнгөн бус хандивын үнэлгээг бодитой тодорхойлсон эсэх;

23.5.5.сонгуулийн зардлын тайланд тусгагдсан бүх тооцоолол үнэн зөв тусгагдсан эсэх;

23.5.6.сонгуулийн зардлын зарцуулалт зориулалтын дагуу бодитой хийгдсэн бөгөөд анхан шатны баримтыг үндэслэн сонгуулийн зардлын тайланд үнэн зөв тусгагдсан эсэх.

23.6.Аудитын хуулийн этгээд сонгуулийн зардлын эцсийн тайланд аудит хийхдээ Аудитын олон улсын стандартыг баримталж, Аудитын олон улсын стандарт 800 “Тусгай зорилго бүхий үзэл баримтлалд нийцүүлэн бэлтгэсэн санхүүгийн тайлангийн аудит”-г удирдлага болгоно.

ТАВДУГААР БҮЛЭГ. БУСАД ЗААЛТ

Хорин дөрөв. Сонгуулийн зардлын ил тод байдлыг хангахад иргэн болон олон нийтийн байгууллагын оролцоо

24.1.Сонгуулийн зардлын ил тод байдлыг хангахад иргэн болон олон нийтийн байгууллага дараах оролцоотой байна:

24.1.1.сонгуулийн зардлыг ил тод байдлыг хангахад чиглэсэн хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавихад оролцох, хөндлөнгийн ажиглалт хийх;

24.1.2.сонгуулийн зардалтай холбоотой гарсан зөрчил, гэмт хэргийн шинжтэй үйлдлийн талаар Үндэсний аудитын газар болон мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллагад гомдол, мэдээлэл гаргах;

24.1.3.нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайланг үнэн зөв, бодитой гаргасан эсэх талаар дүн шинжилгээ хийх, санал, зөвлөмж гаргах.

Хорин тав. Хариуцлага

25.1.Үндэсний аудитын газар нь сонгуулийн зардлын тайлангийн аудитын дүгнэлтийг үнэн зөв, бодитой гаргаагүй, илт худал дүгнэлт гаргасан, эсхүл хуульд заасныг зөрчиж аудит хийсэн аудитын хуулийн этгээдийг тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулах саналаа санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлнэ.

25.2.Үндэсний аудитын газар сонгуулийн зардлын тайланд аудит хийх явцад гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй үйл баримт илэрсэн тохиолдолд энэ тухайн мэдээллийг холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлж шалгуулна.

25.3.Үндэсний аудитын газрын хийсэн аудитын дүгнэлт, түүний мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээг Төрийн аудитын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд зааснаар зохицуулна.

----ooOOoo----

НАМЫН СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ

Маягт-1

Тайлан ирүүлсэн огноо:

... оны ...-р сарын ...-ны өдөр

Тайлангийн төрөл:

- ☐ Сонгуулийн өдрөөс 3 хоногийн өмнөх явцын тайлан
☐ Сонгуулийн дараах эцсийн тайлан

НЭГ. НАМЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ		
Намын нэр:		
Регистрийн дугаар:		
Нэр дэвшүүлсэн хүний тоо:		
ХОЁР. ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ		
Сонгуулийн зардлын данс нээлгэсэн банкны нэр:		
Дансны дугаар:		
Гүйлгээ хийж эхэлсэн огноо:	... оны ...-р сарын ...-ны өдөр	
Хамгийн сүүлд гүйлгээ хийсэн огноо:	... оны ...-р сарын ...-ны өдөр	
Аймаг, нийслэл, сум, дүүрэгт зардлын данстай эсэх:	☐ Тийм ☐ Үгүй	
Хэрэв тийм бол:		
Орон нутгийн салбарын нийт дансны тоо:		
Нийт орлого:	_____ төгрөг	
Нийт зарлага:	_____ төгрөг	
ГУРАВ. НАМЫН СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН		
Үзүүлэлт	Хэмжээ /төгрөгөөр/	Тоо
1. НИЙТ ОРЛОГЫН ДҮН		
1.1 Намын өөрийн хөрөнгө		
1.2 Хуулийн этгээдээс өгсөн мөнгөн хандив		
1.3 Иргэнээс өгсөн мөнгөн хандив		
2. НИЙТ ЗАРДЛЫН ДҮН		
2.1 Шууд зардлын дүн		
2.1.1 Нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгаанд зориулж олгосон зардал		
2.1.2 Сонин, сэтгүүл, ухуулах хуудас, зурагт самбарт байршуулах хуудас, намын далбаа, уриа, таних тэмдэг бүхий хуудас, хувцас хэвлүүлэх зардал		
2.1.3 Телевиз, радио, өдөр тутмын болон бусад сонин сэтгүүл, цахим орчин ашигласны зардал		
2.1.4 Сонгогчидтой хийсэн хурал, цуглаан, уулзалтын зардал		
2.1.5 Ухуулах байр, сонгуулийн сурталчилгаанд ашиглагдах тээврийн хэрэгсэл, бусад тоног төхөөрөмж/чанга яригч, дэлгэц/-ийн түрээсийн болон тэдгээрийг худалдаж авсан зардал		
2.1.6 Шатахууны зардал		
2.1.7 Сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан, менежер, шадар туслах, ухуулагч, ажиглагчийн цалин, урамшуулал		
2.2 Шууд бус зардлын дүн		
2.2.1 Бараа, ажил, үйлчилгээ худалдаж авсан зардал		
2.2.2 Сонгууль эрхэлсэн байгууллага, түүний бүрэлдэхүүний ажлын хэрэгцээнд ашигласан эд хөрөнгийн түрээсийн зардал		
2.2.3 Захиргааны зардал		
2.2.4 Бусад зардал		
3. ҮЛДЭГДЭЛ, БАЙРШИЛ		
4. ТӨЛӨГДӨӨГҮЙ БАЙГАА ӨР ТӨЛБӨР		
5. ХУУЛИАР ЗӨВШӨӨРӨГДӨӨГҮЙ ХАНДИВ		
5.1 Буцаасан хандив		

5.1 Улсын орлого болгосон хандив		
(Анхаарах: Дээрх бүх бүх гүйлгээ дансаар хийгдсэн байна)		
ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:	/ Овог нэр /	
	/ Албан тушаал /	
ТАЙЛАН ХЯНАСАН:	/ Овог нэр /	
	/ Албан тушаал /	

ЭВСЛИЙН СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ

Маягт-1

Тайлан ирүүлсэн огноо:

... оны ...-р сарын ...-ны өдөр

Тайлангийн төрөл:

- ☐ Сонгуулийн өдрөөс 3 хоногийн өмнөх явцын тайлан
☐ Сонгуулийн дараа эцсийн тайлан

НЭГ. ЭВСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ		
Эвслийн нэр:		
Эвсэлд нэгдсэн намын тоо:		
Нэр дэвшүүлсэн хүний тоо:		
ХОЁР. ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ		
Сонгуулийн зардлын данс нээлгэсэн банкны нэр:		
Дансны дугаар:		
Гүйлгээ хийж эхэлсэн огноо:	... оны ...-р сарын ...-ны өдөр	
Хамгийн сүүлд гүйлгээ хийсэн огноо:	... оны ...-р сарын ...-ны өдөр	
ГУРАВ. ЭВСЛИЙНН СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН		
Үзүүлэлт	Хэмжээ /төгрөгөөр/	Тоо
1. НИЙТ ОРЛОГЫН ДҮН		
1.1 Намуудаас оруулсан өөрийн хөрөнгө		
Нам 1 /нэр/		
Нам 2 /нэр/		
Нам 3 /нэр/		
...		
1.2 Хуулийн этгээдийн хандив		
1.3 Иргэний хандив		
2. НИЙТ ЗАРДЛЫН ДҮН		
2.1 Шууд зардлын дүн		
2.1.1 Нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгаанд зориулж олгосон зардал		
2.1.2 Сонин, сэтгүүл, ухуулах хуудас, зурагт самбарт байршуулах хуудас, намын далбаа, уриа, таних тэмдэг бүхий хуудас, хувцас хэвлүүлэх зардал		
2.1.3 Телевиз, радио, өдөр тутмын болон бусад сонин сэтгүүл, цахим орчин ашигласны зардал		
2.1.4 Сонгогчидтой хийсэн хурал, цуглаан, уулзалтын зардал		
2.1.5 Ухуулах байр, сонгуулийн сурталчилгаанд ашиглагдах тээврийн хэрэгсэл, бусад тоног төхөөрөмж/чанга яригч, дэлгэц/-ийн түрээсийн болон тэдгээрийг худалдаж авсан зардал		
2.1.6 Шатахууны зардал		
2.1.7 Сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан, менежер, шадар туслах, ухуулагч, ажиглагчийн цалин, урамшуулал		
2.2 Шууд бус зардлын дүн		
2.2.1 Бараа, ажил, үйлчилгээ худалдаж авсан зардал		
2.2.2 Сонгууль эрхэлсэн байгууллага, түүний бүрэлдэхүүний ажлын хэрэгцээнд ашигласан эд хөрөнгийн түрээсийн зардал;		
2.2.3 Захиргааны зардал		
2.2.4 Бусад зардал		
3. ҮЛДЭГДЭЛ, БАЙРШИЛ		
4. ТӨЛӨГДӨӨГҮЙ БАЙГАА ӨР ТӨЛБӨР		
5. ХУУЛИАР ЗӨВШӨӨРӨГДӨӨГҮЙ ХАНДИВ		

5.1 Буцаасан дүн		
5.1 Улсын орлого болгосон		
(Анхаарах: Дээрх бүх бүх гүйлгээ дансаар хийгдсэн байна)		
ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:		/ Овог нэр /
		/ Албан тушаал /
ТАЙЛАН ХЯНАСАН:		/ Овог нэр /
		/ Албан тушаал /

НЭР ДЭВШИГЧИЙН СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ

Маягт-1

Тайлан ирүүлсэн огноо:

... оны ...-р сарын ...-ны өдөр

Тайлангийн төрөл:

- ☐ Сонгуулийн өдрөөс 3 хоногийн өмнөх явцын тайлан
☐ Сонгуулийн дараах эцсийн тайлан

НЭГ. НЭР ДЭВШИГЧИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Ургийн овог: _____
 Эцэг /эх/-ийн нэр: _____
 Өөрийн нэр: _____
 Регистрийн дугаар: _____
 Сонгуулийн тойрог: _____

€ нам/эвсэл/-аас нэр дэвшигч € бие даан нэр дэвшигч

ХОЁР. ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

Сонгуулийн зардлын данс нээлгэсэн банкны нэр: _____
 Дансны дугаар: _____
 Гүйлгээ хийж эхэлсэн огноо: ... оны ...-р сарын ...-ны өдөр
 Хамгийн сүүлд гүйлгээ хийсэн огноо: ... оны ...-р сарын ...-ны өдөр

ГУРАВ. НЭР ДЭВШИГЧИЙН СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Үзүүлэлт		Хэмжээ /төгрөгөөр/	Тоо
1. НИЙТ ОРЛОГЫН ДҮН			
1.1 Нам/эвслээс оруулсан мөнгөн хөрөнгө /бие даан нэр дэвшигчид хамаарахгүй/			
1.2 Нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө			
1.3 Хуулийн этгээдийн өгсөн нийт хандив			
	1.3.1 Мөнгөн хандив		
	1.3.2 Мөнгөн бус хандив		
1.4 Иргэний өгсөн нийт хандив			
	1.4.1 Мөнгөн хандив		
	1.4.1 Мөнгөн бус хандив		
2. НИЙТ ЗАРДЛЫН ДҮН			
2.1 Шууд зардлын дүн			
	2.1.1 Сонин, сэтгүүл, ухуулах хуудас, зурагт самбарт байршуулах хуудас, намын далбаа, уриа, таних тэмдэг бүхий хуудас, хувцас хэвлүүлэх зардал		
	2.1.2 Телевиз, радио, өдөр тутмын болон бусад сонин сэтгүүл, цахим орчин ашигласны зардал		
	2.1.3 Сонгогчидтой хийсэн хурал, цуглаан, уулзалтын зардал		
	2.1.4 Ухуулах байр, сонгуулийн сурталчилгаанд ашиглагдах тээврийн хэрэгсэл, бусад тоног төхөөрөмж/чанга яригч, дэлгэц/-ийн түрээсийн болон тэдгээрийг худалдаж авсан зардал;		
	2.1.5 Шатахууны зардал		
	2.1.6 Сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан, менежер, шадар туслах, ухуулагч, ажиглагчийн цалин, урамшуулал		
2.2 Шууд бус зардлын дүн			
	2.2.1 Бараа, ажил, үйлчилгээ худалдаж авсан зардал		

2.2.2 Сонгууль эрхэлсэн байгууллага, түүний бүрэлдэхүүний ажлын хэрэгцээнд ашигласан эд хөрөнгийн түрээсийн зардал		
2.2.3 Захиргааны зардал		
2.2.4 Бусад зардал		
3. ҮЛДЭГДЭЛ, БАЙРШИЛ		
4. ТӨЛӨГДӨӨГҮЙ БАЙГАА ӨР ТӨЛБӨР		
5. ХУУЛИАР ЗӨВШӨӨРӨГДӨӨГҮЙ ХАНДИВ		
5.1 Буцаасан дүн		
5.1 Улсын орлого болгосон		
(Анхаарах: Дээрх бүх бүх гүйлгээ дансаар хийгдсэн байна)		
ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:	/ Овог нэр / / Албан тушаал /	
ТАЙЛАН ХЯНАСАН:	/ Нэр дэвшигч /	

НАМ, ЭВСЛИЙН СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ДАНСАНД ТӨВЛӨРҮҮЛЭН

НАМЫН ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ТАЙЛАН /Маягт-2/

Нам/эвсэл/-ийн нэр _____

Нийт дүн: _____

№	Шилжүүлэг хийсэн огноо	Мөнгөн дүн	Эх үүсвэр
1.			
2.			
3.			

Заавар: Мөнгөн дүн, огноо, эх үүсвэрийг гүйлгээ тус бүрээр нэг бүрчлэн бичнэ. Нам, эвсэл сонгуулийн зардлын дансандаа төвлөрүүлсэн намын өөрийн хөрөнгийг ямар эх үүсвэрээс бүрдүүлсэн талаараа үнэн зөв, тодорхой бичнэ.

Тайлан бэлтгэсэн:

/овог, нэр/
/албан тушаал/

Тайлан хянасан:

/овог, нэр/
/албан тушаал /

НЭР ДЭВШИГЧИЙН СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ДАНСАНД ТӨВЛӨРҮҮЛСЭН НЭР ДЭВШИГЧИЙН ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ТАЙЛАН /Маягт-2/

Нэр дэвшигчийн овог, нэр: _____

Нийт дүн: _____

№	Шилжүүлэг хийсэн огноо	Мөнгөн дүн	Эх үүсвэр
1.			
2.			
3.			

Заавар: Мөнгөн дүн, огноо, эх үүсвэрийг гүйлгээ тус бүрээр нэг бүрчлэн бичнэ. Нэр дэвшигч сонгуулийн зардлын дансандаа төвлөрүүлсэн өөрийн хөрөнгийг ямар эх үүсвэрээс бүрдүүлсэн талаараа үнэн зөв, тодорхой бичнэ.

Тайлан бэлтгэсэн:

/овог, нэр/
/албан тушаал/

Тайлан хянасан:

/нэр дэвшигч/

МӨНГӨН ХАНДИВЫН ТАЙЛАН /Маягт-3/

(Иргэнээс авсан мөнгөн хандив)

№	Хандивлагч		Хандивын хэмжээ /төгрөг/	Хандивын эх үүсвэр*	Хандивласан огноо
	Нэр	Регистрийн дугаар			
1.					
2.					
3.					
Нийт дүн					

*Хандивын эх үүсвэрийн мэдээллийг зөвхөн банкны гүйлгээний баримтад тусгагдсан байдлаар бичнэ.

Тайлан бэлтгэсэн:

/овог, нэр/
/албан тушаал/

Тайлан хянасан:

/овог, нэр/
/нэр дэвшигч, эсхүл нам, эвслийн эрх бүхий
албан тушаалтан/

(Хуулийн этгээдээс авсан мөнгөн хандив)

№	Хандивлагч		Хандивын хэмжээ /төгрөг/	Хандивын эх үүсвэр*	Хандивласан огноо
	Нэр	Регистрийн дугаар			
1.					
2.					
3.					
Нийт дүн					

*Хандивын эх үүсвэрийн мэдээллийг банкны гүйлгээний баримтад тусгагдсан байдлаар бичнэ.

Заавар: Зөвхөн хуулиар зөвшөөрөгдсөн мөнгөн хандивыг энэ маягтын дагуу тайлагнах ба тайланг мөнгөн хандивын гүйлгээ тус бүрээр нэг бүрчлэн гаргана.

Тайлан бэлтгэсэн:

/овог, нэр/
/албан тушаал/

Тайлан хянасан:

/овог, нэр/
/нэр дэвшигч, эсхүл нам, эвслийн эрх бүхий
албан тушаалтан/

МӨНГӨН БУС ХАНДИВЫН ТАЙЛАН /Маягт-4/

(Иргэнээс авсан мөнгөн бус хандив)

№	Хандивлагч		Хандивлагчийн хаяг	эд хөрөнгө болон авсан үйлчилгээний мэдээлэл, хандивын зориулалт*	Гэрээний дугаар	Хандивын хэмжээ /хандивын гэрээнд зааснаар/	огноо
	Нэр	Регистрийн дугаар					
1.							
2.							
3.							
Нийт дүн							

Тайлан бэлтгэсэн:

/овог, нэр/
/албан тушаал/

Тайлан хянасан:

/нэр дэвшигч/

МӨНГӨН БУС ХАНДИВЫН ТАЙЛАН /Маягт-4/*(Хуулийн этгээдээс авсан мөнгөн бус хандив)*

№	Хандивлагч		Хандивлагчийн хаяг	Эд хөрөнгө болон авсан үйлчилгээний мэдээлэл, хандивын хандивын зориулалт*	Гэрээний дугаар	Хандивын хэмжээ /хандивын гэрээнд зааснаар/	огноо
	Нэр	Регистрийн дугаар					
1.							
2.							
3.							
Нийт дүн							

Заавар: Эзэмшүүлсэн, ашиглуулсан эд хөрөнгө нь үл хөдлөх эд хөрөнгө тохиолдолд улсын бүртгэлийн дугаар, тээврийн хэрэгсэл тохиолдолд улсын дугаар, бусад хөдлөх эд хөрөнгө тохиолдолд хөрөнгийн марк, нэр, эд хөрөнгө эзэмшсэн, ашигласан, авсан үйлчилгээний зориулалтыг тодорхой бичнэ.

Мөнгөн бус хандивын хэмжээг тодорхойлох жишээ:

- Оффисын тоног төхөөрөмж түрээслэх бизнес эрхэлдэггүй этгээд дэвшигчид сонгуулийн сурталчилгааны ажилд нь хувилагч машин үнэ төлбөргүйгээр ашиглуулжээ. Энэ тохиолдолд нэр дэвшигч тухайн орон нутаг дахь ийм төрлийн үйл ажиллагаа явуулдаг этгээдээс уг тоног төхөөрөмжийг ашиглахад ямар хөлс төлөхийг судлах замаар мөнгөн бус хандивын үнэлгээг тодорхойлно.
- Оффисын тоног төхөөрөмж түрээслэх бизнес эрхэлдэг этгээд нэр дэвшигчид сонгуулийн сурталчилгааны ажилд нь хувилагч машин үнэ төлбөргүйгээр ашиглуулсан тохиолдолд уг мөнгөн бус хандивын хэмжээг тухайн этгээд энэ төрлийн үйлчилгээ үзүүлээд авдаг хөлсийн дундаж үнэлгээгээр тодорхойлно.

Тайлан бэлтгэсэн:

/овог, нэр/
/албан тушаал/

Тайлан хянасан:

/нэр дэвшигч/

ХУУЛИАР ЗӨВШӨӨРӨГДӨӨГҮЙ ХАНДИВЫН ТАЙЛАН /Маягт-5/

№	Хандивлагч иргэн, хуулийн этгээдийн нэр /хэрэв мэдэгдэж байгаа бол/	Хандивлагчийн регистрийн дугаар /хэрэв мэдэгдэж байгаа бол/	Хандивын хэмжээ	Хандивын хэлбэр	Огноо	Хуулиар зөвшөөрөгдөөгүй хандив гэж үзсэн тухай тайлбар
1.						
2.						
3.						
Нийт дүн						

Тайлан бэлтгэсэн:

/овог, нэр/
/албан тушаал/

Тайлан хянасан:

/овог, нэр/
/нэр дэвшигч, эсхүл нам, эвслийн эрх бүхий
албан тушаалтан/

**ХУУЛИАР ЗӨВШӨӨРӨГДӨӨГҮЙ ХАНДИВЫГ БУЦААСАН БУЮУ УЛСЫН
ОРЛОГО БОЛГОСОН ТУХАЙ ТАЙЛАН /Маягт-6/**

№	Хандивлагч иргэн, хуулийн этгээдийн нэр <i>/хэрэв мэдэгдэж байгаа бол/</i>	Хандивлагчийн регистрийн дугаар <i>/хэрэв мэдэгдэж байгаа бол/</i>	Хандивын хэмжээ	Шилжүүлгийн мэдээлэл		Буцаасан, улсын орлого болгосон тухай тайлбар	Огноо
				Буцаасан	Улсын орлого болгосон		
1.							
2.							
3.							
Нийт дүн							

Тайлан бэлтгэсэн:

*/овог, нэр/
/албан тушаал/*

Тайлан хянасан:

*/овог, нэр/
/нэр дэвшигч, эсхүл нам, эвслийн эрх бүхий
албан тушаалтан/*

**СОНИН, СЭТГҮҮЛ, УХУУЛАХ ХУУДАС, ЗУРАГТ САМБАРТ БАЙРШУУЛАХ ХУУДАС,
НАМЫН ДАЛБАА, УРИА, ТАНИХ ТЭМДЭГ БҮХИЙ ХУУДАС, ХУВЦАС ХЭВЛҮҮЛЭСНИЙ
ЗАРДЛЫН ТАЙЛАН /Маягт-7/**

№	Зардлын зориулалт	Нэхэмжлэгч этгээдийн		Төлөх дүн	Төлсөн дүн	Төлсөн огноо
		Нэр	Регистрийн дугаар			
1						
2						
3						
4						
Нийт дүн						

Заавар: Энэ маягтаар сонгуулийн сурталчилгааны сонин, сэтгүүл, ухуулах хуудас, зурагт самбар дээр байршуулах хуудас, түүнчлэн намын далбаа, уриа, таних тэмдэг бүхий хуудас, хувцсыг бүтээх, хэвлүүлэхтэй холбоотой гарсан зардлыг тайлагнана.

Тайлан бэлтгэсэн:

/овог, нэр/
/албан тушаал/

Тайлан хянасан:

/овог, нэр/
/нэр дэвшигч, эсхүл нам, эвслийн эрх бүхий
албан тушаалтан/

**ТЕЛЕВИЗ, РАДИО, ӨДӨР ТУТМЫН БОЛОН БУСАД СОНИН СЭТГҮҮЛ, ЦАХИМ ОРЧИН
АШИГЛАСНЫ ЗАРДЛЫН ТАЙЛАН /Маягт-8/**

№	Зардлын зориулалт	Нэхэмжлэгч		Төлөх дүн	Төлсөн дүн	Төлсөн огноо
		Нэр	Регистрийн дугаар			
1						
2						
3						
4						
Нийт дүн						

Заавар: Энэ маягтаар дараах зардлыг тайлагнана:

1. радио, телевизээр дамжуулах сонгуулийн сурталчилгааны контент, шторк бэлтгэх, нэвтрүүлэхтэй холбоотой гаргасан зардал;
2. өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд сонгуулийн сурталчилгааны материал нийтлүүлэх, цахим орчин дахь олон нийтийн сүлжээний болон бусад цахим хуудсаар дамжуулах сонгуулийн сурталчилгааны контент, шторк, бусад сурталчилгааны мэдээлэл бэлтгэх, түүнийг нийтэд түгээхтэй холбоотой гаргасан зардал;
3. нам, эвсэл, нэр дэвшигч өөрийн цахим хуудсаар сурталчилгаа хийхтэй холбоотойгоор домэйн нэр, хостингын төлбөр, цахим хуудсыг бүтээх, цахим хуудсаар дамжуулах сонгуулийн сурталчилгааны контент, шторк, бусад сурталчилгааны мэдээлэл бэлтгэх, цахим хуудсын хөгжүүлэлт, ажиллагаатай холбоотой гаргасан зардал.

Тайлан бэлтгэсэн:

/овог, нэр/
/албан тушаал/

Тайлан хянасан:

/овог, нэр/
/нэр дэвшигч, эсхүл нам, эвслийн эрх бүхий
албан тушаалтан/

**СОНГОГЧИДТОЙ ХИЙСЭН УУЛЗАЛТ, ХУРАЛ, ЦУГЛААНЫ
ЗАРДЛЫН ТАЙЛАН /Маягт-9/**

№	Зардлын зориулалтын тайлбар	Нэхэмжлэгч этгээд		Төлөх дүн	Төлсөн дүн	Төлсөн огноо
		Нэр	Регистрийн дугаар			
1						
2						
3						
Нийт дүн						

Заавар: Энэ маягтаар сонгогчидтой хийсэн уулзалт, хурал, цуглааны үйл ажиллагаанд зориулан гаргасан зардлыг тайлагнана. Зардлын зориулалтын тайлбар дээр хэзээ, хаана болсон уулзалт, хурал, цуглааны талаар тодорхой бичнэ.

Тайлан бэлтгэсэн:

/овог, нэр/
/албан тушаал/

Тайлан хянасан:

/овог, нэр/
/нэр дэвшигч, эсхүл нам, эвслийн эрх бүхий
албан тушаалтан/

**УХУУЛАХ БАЙР, СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНД АШИГЛАГДАХ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ, БУСАД
ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ/ЧАНГА ЯРИГЧ, ДЭЛГЭЦ/-ИЙН ТҮРЭЭСИЙН
БОЛОН ТЭДГЭЭРИЙГ ХУДАЛДАЖ АВСАН ЗАРДЛЫН ТАЙЛАН**

/Маягт-10/

№	Зардлын зориулалтын тайлбар	Нэхэмжлэгч этгээд		Төлөх дүн	Төлсөн дүн	Төлсөн огноо
		Нэр	Регистрийн дугаар			
1						
2						
3						
Нийт дүн						

Тайлан бэлтгэсэн:

/овог, нэр/
/албан тушаал/

Тайлан хянасан:

/овог, нэр/
/нэр дэвшигч, эсхүл нам, эвслийн эрх бүхий
албан тушаалтан/

ШАТАХУУН ЗАРДЛЫН ТАЙЛАН /Маягт-11/

№	Машины дугаар	явсан км	Зарцуулсан шатахуун	Нэхэмжлэгч этгээд		Төлөх дүн	Төлсөн дүн	Төлсөн огноо
				Нэр	Регистрийн дугаар			
1.								
2.								
3.								
4.								
Нийт дүн								

Заавар: Энэ маягтаар сонгуулийн сурталчилгааны зориулалтаар зориулалтаар ашигласан тээврийн хэрэгсэлд зарцуулсан шатахууны зардлыг гүйлгээ тус бүрээр тайлагнана.

Тайлан бэлтгэсэн:

/овог, нэр/
/албан тушаал/

Тайлан хянасан:

/овог, нэр/
/нэр дэвшигч, эсхүл нам, эвслийн эрх бүхий
албан тушаалтан/

ЦАЛИН, УРАМШУУЛЛЫН ЗАРДЛЫН ТАЙЛАН /Маягт-12/

№	Албан тушаалын нэр	Цалин, урамшууллын дүн	Хуулийн дагуу ногдуулсан татвар, шимтгэлийн дүн	Төлсөн дүн	Төлсөн огноо
1					
2					
3					
4					
Нийт дүн					

Заавар: Энэ маягтаар сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан, менежер, шадар туслах, ухуулагч, ажиглагчийн цалин, урамшуулалд зарцуулсан зардлыг гүйлгээ тус бүрээр тайлагнана.

Тайлан бэлтгэсэн:

/овог, нэр/
/албан тушаал/

Тайлан хянасан:

/овог, нэр/
/нэр дэвшигч, эсхүл нам, эвслийн эрх бүхий
албан тушаалтан/

СОНГУУЛИЙН ШУУД БУС ЗАРДЛЫН ТАЙЛАН /Маягт-13/

№	Ажил, үйлчилгээний тайлбар	Нэхэмжлэгч этгээдийн		Төлөх дүн	Төлсөн дүн	Огноо
		Нэр	Регистрийн дугаар			
1						
2						
3						
Нийт дүн						

Заавар: Энэ маягтаар сонгуулийн шууд бус зардалд хамаарах дараах зардлыг тайлагнана:

1. хүнсний, ахуйн хэрэглээний болон бусад хэрэгцээт бараа, материал, тоног төхөөрөмж худалдаж авсан, түүнчлэн бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрт төлсөн зардал;
2. сонгууль эрхэлсэн байгууллага, түүний бүрэлдэхүүний ажлын хэрэгцээнд ашиглахаар эд хөрөнгө /зочид буудал, гэр гэх мэт/-ийн түрээсийн зардал;
3. бичиг хэрэг, шуудан, харилцаа холбоо, интернэтийн төлбөр, банкны шимтгэл, сонгуулийн тойрог, хэсэгт нам, эвслийг төлөөлөн ажиллах хүн олгосон унааны болон албан томилолт гэх мэт захиргааны зардал;
4. бусад зардал.

Тайлан бэлтгэсэн:

/овог, нэр/
/албан тушаал/

Тайлан хянасан:

/овог, нэр/
/нэр дэвшигч, эсхүл нам, эвслийн эрх бүхий
албан тушаалтан/

ТӨЛӨГДӨӨГҮЙ БАЙГАА ӨР ТӨЛБӨРИЙН ТАЙЛАН /Маягт-14/

№	Зардлын зориулалтын тайлбар	Нэхэмжлэгч этгээдийн		Төлөх дүн	Төлөөгүй байгаа шалтгаан, цаашид авах арга хэмжээ
		Нэр	Регистрийн дугаар		
1.					
2.					
3.					
Нийт дүн					

Заавар: Энэ маягтаар сонгуулийн зардлын тайлан гаргах үед бусдад төлөгдөөгүй байгаа өр төлбөрийг тайлагнана.

Тайлан бэлтгэсэн:

/овог, нэр/
/албан тушаал/

Тайлан хянасан:

/овог, нэр/
/нэр дэвшигч, эсхүл нам, эвслийн эрх бүхий
албан тушаалтан/